



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 146

Номгон

**“Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах”
аймгийн дэд хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “ж”, 20 дугаар зүйлийн 20.1.7, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 2/3 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 31 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Иргэдийн эрүүл мэндэд хортойгоор нөлөөлж буй агаар, хөрс, усны бохирдлыг аймгийн хэмжээнд бууруулж, эрүүл орчинд амьдрах таатай боломжийг бүрдүүлэх зорилгоор “Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д ДААЛГАХ нь:

2.1. Жил бүрийн аймгийн төсөвт уул уурхайгаас орох орлогын 10 хувийг “Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах” аймгийн дэд хөтөлбөрт зарцуулсугай.

2.2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гарган аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, хэрэгжилтийг бүтэн жилээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

0117105

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын
29-ний өдрийн 146 дугаар тогтоолын хавсралт



“АГААР, ХӨРС, УСНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Хүний эрүүл мэнд, амьдралын чанар нь хүрээлэн байгаа орчны физик, хими, биологи, нийгэм болон сэтгэл зүйн хүчин зүйлээр тодорхойлогддог. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага “Орчны эрүүл мэнд” гэдэгт өнөөгийн болон ирээдүйд эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болох орчны хүчин зүйлийг тодорхойлох, үнэлэх, хянах, тандах болон урьдчилан сэргийлэх онол практикийн цогц үйл ажиллагаа орно гэж тодорхойлсон.

Эдийн засаг өндөр хурдтай хөгжиж байгаа улс орнуудад хотжилт болон үйлдвэржилтээс шалтгаалсан агаар, ус, хөрсний бохирдол ихээр нэмэгдэж байхад манай улсад стандартын шаардлага хангаагүй ундны ус, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламж, уурын зуух, гэр сууцны галлагаа, автомашины утаанаас шалтгаалсан агаарын бохирдол зэрэг орчны эрсдэлт хүчин зүйлүүд хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

Агаарын бохирдол: Баянхонгор аймгийн хэмжээнд агаар бохирдуулагч хөдөлгөөнт эх үүсвэр 2016 оны тооллогоор 17952 тоологдож, эдгээр хөдөлгөөнт эх үүсвэрийн 75.5-80.2 хувь нь бензинээр, 24.4-19.7 хувь нь дизель түлш хэрэглэдэг байна. Баянхонгор аймгийн хэмжээнд агаар бохирдуулах суурин эх үүсвэрийн тоо 2016 оны байдлаар нийт 12058 айл, өрх, 11-100 кв хүчин чадалтай зуух 180 байгаа бөгөөд эдгээр нь жилд дунджаар 105851 тонн нүүрс, 6983 м³ мод, 14016 тонн аргал, 2865 тонн хөрзөн, 19 тонн шахмал түлш хэрэглэж байгаагийн 95.2 хувийг ердийн галлагаатай жижиг оврын зуух, 4.8 хувийг усан халаалтын болон уурын зуухнууд түлж агаар бохирдуулах бодисуудыг ялгаруулж байна. “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын 2016 оны нэгдсэн тоо, бүртгэл”-ийн дүнгээр аймгийн төвийн 8 багт 10 квт хүртэл хүчин чадалтай 6606 орчим зуух бүртгэгдсэний 66.2 хувь нь энгийн зуух, 33.8 хувь нь сайжруулсан зуух ашиглаж байна.

Хаягдал утааны хүхэрлэг хий-SO₂ дээр 8 уурын зуух, нүүрстөрөгчийн дутуу исэл -CO дээр 7 уурын зуух, азотын ислүүд-NO₂ дээр 5 уурын зуух дээр хүлцэх стандарт хэмжээг давсан, орчны тоосжилт мг/м³ нь хүлцэх стандарт хэмжээг даваагүй байна.

Агаарын жилийн дундаж температур 0.1°C , 1 дүгээр сарын дундаж 18.0°C хүйтэн, 7 дугаар сард 20.0°C орчим дулаан байдаг. Хүйтрээгүй хоногийн тоо 100 орчим хоног, ашигтай температурын нийлбэр 2000°C -ээс их байдаг.

Баянхонгор суманд PM10 тоосны агууламж жилийн ихэнх хугацаанд хүлцэх хэмжээнээс давсан байдаг нь өвлийн улиралд галлагаа, зуны улиралд автомашины хөдөлгөөний эрчмээс хамааран нэмэгддэг. Азотын давхар исэл, хүхэрлэг хийн хэмжээ 2010 оноос хойш агаарт хүлцэх хэмжээнээсээ 25-37 хувиар их тодорхойлогдож байна. Аймгийн хүн амын өвчлөлд 2015 оноос эхлэн амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлэх шалтгаан болж, улс, аймгийн дунджаас өндөр үзүүлэлттэй /10 000 хүн амд 1804.5/ аймгийн тоонд орж байна. Бүртгэгдэж байгаа амьсгалын замын өвчлөлийн 50 гаруй хувь нь 5 хүртэлх насны хүүхдэд тохиолдож, эндэгдлийн тэргүүлэх шалтгааны нэг болж байна.

Усны бохирдол: Нийт 278 гол горхи, 1022 булаг шанд, 88 нуур тойром, 67 рашаан, 2494 худаг, 101 цооног, 14 услалтын систем, 13 хөв цөөрөм, 4 цэвэрлэх байгууламж, 2 үерийн хамгаалалтын далан тоологджээ. Уст цэгийн 67 хувийг гадаргын ус /гол горхи, булаг шанд, нуур тойром, рашаан/, 33 хувийг газрын доорх ус болон усны барилга байгууламж /худаг, цооног, хөв цөөрөм, үерийн хамгаалалтын далан, цэвэрлэх байгууламж, услалтын систем/ эзэлж байна.

Баянхонгор хотын нэг өдрийн усны хэрэглээ нь $2000-2200\text{м}^3$ бөгөөд цэвэрлэх байгууламж нь хоногт $1700-1800\text{м}^3$ усыг хүлээн авч, энгийн механик цэвэрлэгээгээр цэвэрлэдэг.

Мэргэжлийн хяналтын газраас 2015 онд аймгийн төвийн нийт 122 дээжинд нян судлалын шинжилгээ хийхэд 16 дээжинд E-coli /гэдэсний савханцар, 9 дээжинд гэдэсний бүлгийн эмгэг төрөгч бактери илэрсэн гэсэн үзүүлэлттэй, MNS-900:2005 стандартын шаардлага хангасан 88, хангаагүй 34 худаг, 2016 оны шинжилгээний дүнгээр 14 сум, 46 аж ахуй нэгж, 11 сургууль цэцэрлэгийн 71 ундны усны эх үүсвэрт шинжилгээ хийхэд 44 /61.9 хувь/ худаг нь MNS 900:2005 стандартын шаардлагыг хангасан, бусад нь хангаагүй, 2017 оны 01 дүгээр сард Баянхонгор сумын төвлөрсөн шугамны 15 ус түгээх байр, зөөврийн 22 ус түгээх цэгийн усанд нян судлалын үзүүлэлтээр шинжилгээ хийхэд 16 буюу 43 хувьд E.Coli илэрсэн нянгийн бохирдолтой байна.

Баянхонгор аймгийн 20 сумын 34 худгийн усны дээжийг Геологийн төв лабораторид шинжлүүлэхэд хүнцэл, уран, иодын агууламж стандартын шаардлага хангасан, Баянговь сумын 2 дугаар ус түгээх байр, Богд сумын сургууль, Засаг даргын Тамгын газрын харьяа худгийн усанд хар тугалгын агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 2.1-3.4 дахин их, Богд сумын сургууль, эмнэлэг, Баянлиг, Баян-

Овоо, Жинст, Баянцагаан, Баацагаан, Эрдэнэцогт, Гурванбулаг, “Чандмань-Баянхонгор” ХК-ний эх үүсвэрийн худгийн усанд фторын агууламж стандартад заасан доод хэмжээнээс 8.6 дахин бага тодорхойлогдсон байна.

Хөдөө сумдын нийт 66 худгийн усны дээжинд 2016 онд нян судлалын шинжилгээ хийхэд 34 дээжинд E-coli/гэдэсний савханцар, 11 дээжинд гэдэсний бүлгийн эмгэг төрөгч бактери илэрсэн гэсэн үзүүлэлттэй, MNS-900:2005 стандартын шаардлага хангасан 11, нийт дээжний 83.3 хувь нь шаардлага хангахгүй байна. Үүнээс үзэхэд хөдөө сумдын ундны усны нян судлалын үзүүлэлт аймгийн төвтэй харьцуулахад 55.7 хувиар хангалтгүй байгаа нь хөдөө орон нутгийн иргэдийн ундны цэвэр усаар хангагдах нөхцөл байдал аюултай төвшинд байгаа нь харагдаж байна.

2014 онд хийгдсэн “Гидрохимийн шинжилгээний ажлын хүрээнд” Баянхонгор аймгийн 20 сумын нийт 480 уст цэг судалгаанд хамрагдсанаас 400 уст цэг нь худаг болон булгийн ус байсан ба стандарт хангаж байгаа нь 205, хангаагүй 195 уст цэг байсан. Баянхонгор суманд 2009-2011 онуудад ундны уснаас үүдэлтэй халдварт шар өвчин дэгдэлт байдлаар гарч, олон хүн өвчилж байсан ч сүүлийн жилүүдэд халдварт өвчний хөдлөл зүйн улмаас гэдэсний замын халдварт өвчин буурч байгаа хэдий ч халдварын гаралтай суулгалт өвчин гарсаар байна.

Хөрсний бохирдол: Баянхонгор аймгийн төв болон зарим сумдын (Баян-Овоо, Галуут, Жаргалант, Бөмбөгөр) нутгийн хөрснөөс сонгон авсан 50 цэгт 2016 онд 99 төрлийн хүнд металлын бохирдлын төвшинг тодорхойлох хэмжилтийг хийсэн. Хэмжилтийн мэдээг MNS 5850:2008 стандартад заасан хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй харьцуулж үзэхэд 24 цэг дээр хүнцэл, хром, ванади зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 2 дахин давсан, аймгийн хуучин хогийн цэг дэх алтны хаягдал шлам дээр хар тугалга 3 дахин давсан байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас жил бүр Баянхонгор аймгийн төвийн 5 цэгээс /Мазаалай парк, Динозавр парк, 1 дүгээр баг 18 дугаар байр, Дэлгэрэх зах, Есөн эрдэнэ зах/ хөрсний дээж авч нян судлалын үзүүлэлтээр шинжилгээнд хамруулахад нянгийн бохирдол зөвшөөрөгдөх хэмжээнээс 5-20 дахин их, зарим цэгт гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян илэрсэн байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 29 сургууль, 33 цэцэрлэгийн 70 хувь нь хөрсний дээжээ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын нян судлалын лабораторид шинжилгээнд хамруулахад бүх дээжинд нянгийн бохирдол 3-5 дахин их, зарим сумдын болон аймгийн төвийн сургууль цэцэрлэгүүдийн хөрсний дээжинд гэдэсний бүлгийн эмгэгтөрөгч нян илэрч байна.

Хүн амын эрүүл мэндэд нөлөөлж байгаа дээрх орчны /агаар, хөрс, ус/ эрсдлийг бууруулахад чиглэсэн бодлого боловсруулж, үйл ажиллагааг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ зорилгоор “Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах” дэд хөтөлбөрийг боловсруулсан болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зарчим

Хөтөлбөрийн зорилго нь хүрээлэн буй орчныг бохирдуулж буй хүчин зүйлсийг багасгах, орчны эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх, салбар хоорондын зохицуулалт хамтын ажиллагааг сайжруулах замаар хүн амыг эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална.

-Орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагаанд салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах

-Орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, хувь хүний оролцоо, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх

-Хөтөлбөрийг байгаль орчныг хамгаалах, нийгмийн эрүүл мэндийн үндэсний болон бусад хөтөлбөр, орон нутгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх

-Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг өргөнөөр оролцуулах нөхцөлийг бүрдүүлж, тэдний оруулж буй хувь нэмрийг дэмжих

-Хүн амын суурьшлын бүсэд орчныг бохирдуулагч хүчин зүйлсийг эдийн засгийн хөшүүрэг хэрэглэх замаар багасгаж, “Бохирдуулагч нь төлөгч байх зарчим”-ыг тууштай баримтлах

Гурав. Хөтөлбөр хэрэгжих хугацаа

Аймгийн агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах хөтөлбөр нь 2017-2020 он хүртэл

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны чиглэл

Зорилт 1: Агаарын бохирдлыг 50 хувиар бууруулна.

Зорилт 2: Хөрсний бохирдлыг 40 хувиар бууруулна.

Зорилт 3: Усны бохирдлыг 50 хувиар бууруулна.

Зорилт 4: Агаар, хөрс, усанд хими, хүнд металл, цацраг идэвхт бодис, нян судлалын шинжилгээг хийх итгэмжлэгдсэн лабораторитой болох, иргэдийн экологи, нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх.

1. Агаарын бохирдлыг 50 хувиар бууруулах зорилтод хүрэхийн тулд дараах ажлуудыг хэрэгжүүлнэ.

1.1. Ус цаг уур, орчны агаарын бохирдол, хүнд металлыг хэмжиж тодорхойлох шаардлагатай тоног төхөөрөмж бүхий итгэмжлэгдсэн лабораторитой болох

1.2. Агаарын бохирдлыг багасгахад чиглэсэн дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх

1.3. Дулааны станцтай болох

1.4. Эрчим хүчний эх үүсвэр, гэр хорооллын цахилгаан дамжуулах болон түгээх сүлжээг өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх

1.5. Гэр хорооллын өрхөд шаардлагатай эрчим хүчний болон бусад хөнгөлөлт, үйлчилгээг хүргэх, цахилгаан халаагууртай болгох ажлыг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх

1.6. Агаарын бохирдлыг бууруулахад дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн, шинэ санаачилга гаргасан өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх

1.7. Мод тарих, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд байгууллага, хувь хүний оролцоог нэмэгдүүлэх

1.8. Агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

1.9 Баянхонгор сумын 1 дүгээр багийн нам даралтын зуух хэрэглэж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийг төвлөрсөн дулааны системд холбох

2. Хөрсний бохирдлыг 40 хувиар бууруулах зорилтод хүрэхийн тулд дараах ажлуудыг хэрэгжүүлнэ.

2.1. Сум бүрт хөрсний бохирдлыг хянах мониторингийн цэгүүдтэй болох.

2.2. Шинжилгээний дүнд үндэслэн халдваргүйжүүлэлтийг дулааны улиралд тогтмол хугацаанд хийх.

2.3. Эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх.

2.4. Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжаас хөрсөнд үүсгэж байгаа бохирдлыг зогсоох.

2.5. Цагдаагийн газрын камерын хяналтыг орчны бохирдлыг бууруулах чиглэлээр ашиглах.

2.6. Гялгар уутны хэрэглээг хязгаарлах, даавуун тор, улавч үйлдвэрлэх иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжих.

2.7.Төв суурин газрын нийтийн эзэмшлийн талбайг цэцэрлэгжүүлэх, цардмал болгох.

2.8 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгадаг болох.

2.9. Сум бүрт хоёрдогч түүхий эдийг боловсруулах цех байгуулах.

2.10. Үерт автаж болзошгүй газруудад үерийн хамгаалалт далан барих

2.11. Түүхий эдийн захыг суурьшлын бүсээс гаргаж, нядалгааны газартай болох

2.12 Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах

2.13 Хуучны барилгуудын подвольт засварлах, цэвэрлэгээ хийх

3. Усны бохирдлыг 50 хувиар бууруулах зорилтод хүрэхийн тулд дараах ажлуудыг хэрэгжүүлнэ.

3.1.Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх

3.2. Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөх

3.3. Энгийн уурхайн худгуудын доторлогоог байгалийн чулуугаар барьж байгуулах /машины дугуйн доторлогоог халах/

3.4. Баянхонгор сумын магистраль шугамыг PVC хоолойгоор солих /2013 онд 5км шугамыг полиэтилен хоолойгоор сольсон, төв магистраль 14км шугамыг солих шаардлагатай

3.5. Сумын төвүүдийн ундны усны худагт орон нутгийн онцлогт тохирсон зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх, халдваргүйжүүлэх төхөөрөмж суурилуулах

3.6. Усан сангийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн ажлыг мэргэжлийн байгууллагаар тогтмол хугацаанд хийлгэх.

3.7. Ундны усны стандартад нийцсэн савны хэрэглээг бий болгох.

3.8. “Чандмань Баянхонгор” ХК итгэмжлэгдсэн лабораторитой болох

3.9. Ахуйн хаягдал усыг дахин хэрэглэх

3.10. Хүн амд ундны усны чанар, аюулгүй байдал болон сайжруулсан ариун цэврийн байгууламжийн талаар мэдлэг, ойлголт бий болгох, эрүүл амьдрах хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааг өргөжүүлэх

4. Агаар, хөрс, усанд хими, хүнд металл, цацраг идэвхт бодис, нян судлалын шинжилгээ хийх итгэмжлэгдсэн лабораторитой болох, иргэдийн экологи, нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилтод хүрэхийн тулд дараах ажлуудыг хэрэгжүүлнэ.

4.1. Одоо ажиллаж байгаа лабораторийг түшиглэн агаар, хөрс, усанд хими, хүнд металл, цацраг идэвхт бодис, нян судлалын үзүүлэлтүүдээр шинжилгээ хийх итгэмжлэгдсэн лабораторитой болох.

4.2. Иргэдийн экологи, нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх.

4.3. Эрүүл ахуйн тухай хуулийг сурталчилан, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Тав. Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

5.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

5.1.1 Агаарын бохирдлыг 50 хувиар бууруулна.

5.1.2 Хөрсний бохирдлыг 40 хувиар бууруулна.

5.1.3 Усны бохирдлыг 50 хувиар бууруулна.

5.1.4 Баянхонгор аймагт агаар, хөрс, усанд хими, хүнд металл, цацраг идэвхит бодис, нян судлалын шинжилгээг хийх итгэмжлэгдсэн лабораторитой болж, иргэдийн экологи, нийгмийн эрүүл мэндийн боловсрол 30 хувиар дээшилсэн байна.

5.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөө, үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэх бөгөөд 2016 оны мэдээллийг суурь үзүүлэлт болгож ашиглана.

Хөтөлбөрийн зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин		Мэдээллийн эх сурвалж
				2018 он	2020 он	
Үр нөлөөний шалгуур үзүүлэлт						
Зорилго Хүрээлэн буй орчныг бохирдуулж буй хүчин зүйлсийг багасгах, орчны эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх, салбар хоорондын зохицуулалт хамтын ажиллагааг сайжруулах замаар хүн амыг эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх	Амьсгалын замын цочмог халдварт өвчлөлийн түвшин	10 000 хүн амд	338.5	282.08	235.1	Эрүүл мэндийн газар
	Амьсгалын замын өвчлөлөөс шалтгаалсан нас баралт	10 000 хүн амд	2.37	1.97	1.64	Эрүүл мэндийн газар
	5 хүртэлх насны хүүхдийн уушигны хатгалгаа өвчний өвчлөлийн түвшин	10 000 хүн амд	643.8	429.2	330.1	Эрүүл мэндийн газар
	Халдварын гаралтай суулгалт халдварын өвчлөл	10 000 хүн амд	1.8	1.5	1.25	Эрүүл мэндийн газар
Зорилт 1 Агаарын бохирдлыг 50 хувиар бууруулах	Итгэмжлэгдсэн лабораторийн тоо	Тоо	0	0	1	Цаг уур, орчны шинжилгээний газар
	Агаар бохирдуулагч хөдөлгөөнт эх	Тоо	17952	10%-р бууруулах	10%-р бууруу	Замын цагдаагийн газар

	үүсвэрийн тоо				улах	
	Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн тоо	Тоо	12058	10%-р бууруулах	20%-р бууруулах	БОАЖГ
	Агаарын тухай хуулийн дагуу хөнгөлөлт, урамшуулалд хамрагдсан иргэн, байгууллагын тоо	Тоо	0	Бүртгэгдсэнээр	Бүртгэгдсэнээр	БОАЖГ
	Шахмал түлш үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгжийн тоо	Тоо	0	Бүртгэгдсэнээр	Бүртгэгдсэнээр	Хүнс, хөдөө аж ахуй, ЖДҮ н газар
	Аймгийн төвийн эрсдэлт бүлгийн хүн амыг томуугийн эсрэг дархлаажуулалтад хамруулсан хувь	Хувь	10%	30%	50%	ЭМГ
Зорилт 2	Хөрсөн дэх гэдэсний савханцрын тоо нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн дээжийн хувь	Хувь	100%	80%	60%	МХГ
Хөрсний бохирдлыг хувиар бууруулах 40	Хөрсөн дэх Перфрингенсийн тоо нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн дээжийн хувь	Хувь	100%	80%	60%	МХГ
	Хог хаягдлыг халдваргүйжүүлэх жижиг оврын автоклаваар хангагдсан сумын хувь	Хувь	10%	35%	60%	ЭМГ
Зорилт 3	Ундны усан дахь гэдэсний савханцрын тоо нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн дээжийн хувь	Хувь	56%	42%	28%	МХГ
Усны бохирдлыг хувиар бууруулах 50	Ундны усан дахь нянгийн ерөнхий тоо нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн дээжийн хувь	Хувь	61%	46%	30%	МХГ
Зорилт 4	Магадлан итгэмжлэгдсэн лабораторийн тоо	Тоо	0	0	1	МХГ
Агаар, хөрс, усанд хими,						

хүнд металл, цацраг идэвхт бодис, нян судлалын шинжилгээг хийх итгэмжлэгдсэн лабораторитой болох, иргэдийн экологи, нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх	Орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хүн амд хийгдсэн мэдээлэл, сургалт сурталчилгааны компанит ажил, аяны тоо	Тоо	2	4	8	ЭМГ
---	---	-----	---	---	---	-----

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулал

6.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газар удирдана.

6.2 Хөтөлбөрийг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хамт олон, иргэд хэрэгжүүлнэ.

6.3 Хөтөлбөрийн зорилго, зорилт тус бүрийг чиглүүлэх мэргэжилтний бүрэлдэхүүнийг аймгийн Эрүүл мэндийн газар хариуцна.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

7.1 Улсын болон орон нутгийн төсөв /аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө/

7.2 Олон Улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилт

7.3 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын хөрөнгө, хандив

Найм. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ

8.1 Аймгийн Засаг даргын Тамгын газраас томилогдсон баг хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр үнэлж, зөвлөмж гаргана.

8.2 Эрүүл мэндийн газар нь хүний эрүүл мэндэд хортойгоор нөлөөлж буй эсхэд үр дүнд суурилсан хяналт үнэлгээ, шинжилгээг хийж ажилдаа хэрэгжүүлэн ажиллана.